

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/143/НА-СТА-ТШЗ

Цахим
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

хуудас:

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас:261885 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: Л.Насанбуян
Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	6
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал.....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	24
4.5.1 Завсрын аудитын талаар	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Төлбөрийн акт	25
5.3 Зөвлөмж.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МУК	Монгол Улсын Консерватори
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026. 02.25 № 06/402
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Консерваторийн багш, ажилчдын орон тоог 2013 онд 245 байхаар баталсан, үндсэн багш нарын орон тоо хүрэлцээгүйгээс 112 багшийг батлагдсан орон тооноос гадна хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Консерваторийн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар тогтоолын дагуу сургалтын төлбөрийг нэмэгдүүлж шинэчлэн баталсан, сургуулийн гадаад оюутнуудын тоо өмнөх жилээс 25-аар нэмэгдсэн зэргээс шалтгаалж, үндсэн, туслах үйл ажиллагааны орлого өмнөх оноос 504,850.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Бусад асуудал

Монгол Улсын Консерваторийн бүжиг, циркийн мэргэжлийн сургалт явуулах зориулалтын хичээлийн байр байхгүйгээс Чингэлтэй дүүрэгт 450 м2 циркийн сургалтын барилга, байгууламжийг түрээсэлж, 70 оюутан, сурагч, 11 багш сургалтын үйл ажиллагаа явуулж, тайлант онд 185,000.0 мянган төгрөгийн түрээсийн зардал бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	240,763,706.15	1,237,962,436.87
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	6,657,995.00	6,657,995.50
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,657,995.00	6,657,995.50
31210	Төгрөг	6,657,995.00	6,657,995.50
31211	Төрийн сангийн харилцах	6,657,995.00	6,657,995.50
33	АВЛАГА	92,989,856.00	1,079,793,890.92
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	374,071,945.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	92,989,856.00	705,092,071.49
33500	Бусад авлага	-	629,874.43
33510	Байгууллагаас авах авлага	-	629,874.43
35	БАРАА МАТЕРИАЛ	141,115,855.15	151,510,550.45
35100	Түүхий эд материал	1,023,198.00	631,711.00
35130	Эм боох материал	1,023,198.00	631,711.00
35400	Хангамжийн материал	140,092,657.15	150,878,839.45
35410	Бичиг хэргийн материал	1,822,700.00	1,680,260.00
35420	Аж ахуйн материал	51,135,288.07	53,442,196.52
35450	Барилгын засварын материал	1,486,600.00	4,090,580.00
35470	Бусад хангамжийн материал	85,648,069.08	91,665,802.93
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,933,330,812.87	9,905,437,653.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,933,330,812.87	9,905,437,653.58
39200	Биет хөрөнгө	9,102,808,663.19	9,075,890,837.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,147,875,532.74	8,147,875,532.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	(987,471,113.78)	(1,109,036,262.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,950,000.00	66,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,858,333.51)	(32,363,889.11)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,145,204,359.32	2,237,530,563.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	(474,196,287.98)	(484,722,690.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	195,330,839.03	193,016,459.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(108,576,700.89)	(87,799,910.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,958,000.00	16,958,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,060,583.55)	(5,169,916.91)
39217	Ном	132,652,951.81	132,652,951.81
39300	Биет бус хөрөнгө	830,522,149.68	829,546,816.32
39301	Програм хангамж	12,630,000.00	12,630,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,150,250.32)	(8,125,583.68)
39303	Бусад биет бус хөрөнгө	825,042,400.00	825,042,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	10,174,094,519.02	11,143,400,090.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	322,309,493.12	296,910,196.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	322,309,493.12	296,910,196.55

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41300	Өглөг	322,309,493.12	155,246,691.55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	322,082,393.12	52,132,859.01
41360	Бусад өглөг	227,100.00	103,113,832.54
41361	Байгууллагад төлөх өглөг	227,100.00	103,113,832.54
41400	Урьдчилж орсон орлого	-	141,663,505.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	141,663,505.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,851,785,025.90	10,846,489,893.90
51	Засгийн газрын хувь оролцоо	9,851,785,025.90	10,846,489,893.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,010,432,655.62	8,010,432,655.62
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	8,010,432,655.62	8,010,432,655.62
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,233,321,242.63)	(1,238,616,374.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,128,527,410.29)	(2,233,321,242.63)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,104,793,832.34)	994,704,868.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,074,673,612.91	4,074,673,612.91
6	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,174,094,519.02	11,143,400,090.45

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	8,383,508,143.03	10,752,439,544.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,212,007,888.80	10,752,439,544.20
120	Нийтлэг татварын бус орлого	1,212,007,888.80	1,703,575,239.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	731,484,819.00	1,468,743,806.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	664,325,496.00	1,410,260,756.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,159,323.00	58,483,050.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	476,293,178.00	224,483,703.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,229,891.80	10,347,729.85
122	Тусламжийн орлого	-	9,048,864,304.77
1221	Хандив тусламж /дотоод/	-	9,048,864,304.77
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	8,804,510,899.77
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	8,804,510,899.77
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	244,353,405.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	244,353,405.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,171,500,254.23	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,846,801,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,846,801,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	324,698,954.23	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	6,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	298,798,954.23	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,585,906,732.14	9,757,734,676.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,585,906,732.14	9,757,734,676.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,215,815,267.82	9,298,765,633.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,197,071,418.53	7,285,336,027.67
210101	Үндсэн цалин	4,346,945,416.89	4,987,329,351.41
210102	Нэмэгдэл	1,539,065,386.64	1,760,483,376.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,384,215.00	389,839,500.00
210104	Урамшуулал	154,676,400.00	147,059,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	624,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	748,126,675.83	857,984,328.02
210201	Тэтгэврийн даатгалын зардал	520,500,324.86	592,392,126.47
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	63,652,887.89	71,975,378.90
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	35,304,379.49	38,989,663.40
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	24,265,115.92	30,402,714.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	104,403,967.67	124,224,445.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,161,200.00	439,098,700.00
210301	Гэрэл, цахилгаан	76,953,107.63	102,799,311.94
210302	Түлш, халаалт	80,876,839.92	108,113,048.11

**Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	40,331,252.45	43,186,339.95
210304	Байрны түрээс	165,000,000.00	185,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,177,776.96	41,228,783.81
210401	Бичиг хэрэг	6,227,000.00	7,395,332.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,114,833.00	14,257,320.26
210404	Ном, хэвлэл	165,500.00	1,196,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,747,300.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,056,352.86	10,171,775.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,070,160.00	1,260,275.00
210408	Бараа материал акталсны зардал	30,796,631.10	6,647,281.55
2105	Нормативт зардал	84,454,894.00	113,298,912.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	295,194.00	1,004,612.00
210502	Хоол, хүнс	83,177,700.00	112,294,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	982,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,998,480.00	20,048,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,385,000.00	-
210604	Урсгал засвар	27,613,480.00	20,048,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,414,642.81	274,061,414.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	266,300,742.81	206,347,710.28
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,805,900.00	58,743,604.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	43,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,264,500.00	8,970,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	435,410,179.69	267,708,617.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	752,400.00	2,744,555.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,765,350.90	1,627,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	407,892,428.79	263,336,362.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	370,091,464.32	458,969,043.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	86,215,757.67
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	86,215,757.67
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	86,215,757.67
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	22,592,767.92
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	63,622,989.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	223,896,928.11	372,753,285.46
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,325,400.00	92,387,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	127,261,847.11	280,366,185.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,309,681.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	146,194,536.21	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,312,973.81	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	28,881,562.40	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(202,398,589.11)	994,704,868.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	902,395,243.23	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	902,395,243.23	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(902,395,243.23)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(1,104,793,832.34)	994,704,868.00

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,914,187,073.23	10,378,189,527.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	731,484,819.00	10,378,189,527.35
120	Нийтлэг татварын бус орлого	731,484,819.00	1,236,335,366.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	731,484,819.00	1,236,335,366.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	664,325,496.00	1,177,852,316.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,159,323.00	58,483,050.00
122	Тусламжийн орлого	-	9,141,854,160.77
1221	Хандив тусламж /дотоод/	-	9,141,854,160.77
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгоон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	8,804,510,899.77
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	8,804,510,899.77
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	337,343,261.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	337,343,261.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,182,702,254.23	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,846,801,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,846,801,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	335,900,954.23	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	310,000,954.23	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,912,257,173.23	10,367,230,026.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,912,257,173.23	10,367,230,026.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,449,175,852.91	9,203,168,912.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,892,833,876.24	7,460,235,636.95
210101	Үндсэн цалин	4,065,171,387.45	5,167,979,402.02
210102	Нэмэгдэл	1,535,024,172.30	1,755,320,545.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	155,844,794.66	389,270,505.11
210104	Урамшуулал	136,793,521.83	147,059,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	605,384.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	725,004,300.00	950,311,900.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	501,693,975.06	684,720,644.45
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	61,740,805.45	71,974,378.90
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	35,669,679.32	38,989,663.40
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	24,760,145.98	30,402,714.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	101,139,694.19	124,224,499.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,161,200.00	438,891,900.00
210301	Гэрэл, цахилгаан	76,953,107.63	102,799,311.94
210302	Түлш, халаалт	80,876,839.92	107,906,248.11
210303	Цэвэр, бохир ус	40,331,252.45	43,186,339.95

**Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210304	Байрны түрээс	165,000,000.00	185,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,929,273.00	24,254,500.00
210401	Бичиг хэрэг	3,731,600.00	4,438,230.74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,114,833.00	9,737,400.26
210404	Ном, хэвлэл	-	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,747,300.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,335,540.00	9,628,869.00
2105	Нормативт зардал	83,918,500.00	113,177,425.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	480,850.00	883,125.00
210502	Хоол, хүнс	83,177,700.00	112,294,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	259,950.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,890,200.00	30,168,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,968,500.00	7,524,540.00
210602	Тавилга	-	1,188,000.00
210604	Урсгал засвар	26,921,700.00	21,455,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,217,092.81	180,145,410.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	291,103,192.81	174,200,010.28
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,805,900.00	3,245,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	43,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,264,500.00	2,700,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,221,410.86	5,983,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,371,500.00	1,888,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,849,910.86	4,095,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463,081,320.32	1,164,061,114.62
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	791,307,829.16
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	791,307,829.16
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	791,307,829.16
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	628,328,133.92
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	162,979,695.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	223,896,928.11	372,753,285.46
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,325,400.00	92,387,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	127,261,847.11	280,366,185.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,309,681.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	239,184,392.21	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,312,973.81	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	121,871,418.40	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,929,900.00	10,959,500.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,929,900.00	10,959,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,929,900.00	10,959,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,929,900.00	10,959,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,929,900.00	10,959,500.00

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,929,900.00)	(10,959,500.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	0.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,657,995.00	6,657,995.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,657,995.00	6,657,995.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,326,057,829.91	(2,379,911,627.29)	10,956,578,858.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,251,384,217.00	1,251,384,217.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,010,432,655.62	5,326,057,829.91	(1,128,527,410.29)	12,207,963,075.24
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,251,384,217.00)	-	(1,251,384,217.00)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,104,793,832.34)	(1,104,793,832.34)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	4,074,673,612.91	(2,233,321,242.63)	9,851,785,025.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,010,432,655.62	4,074,673,612.91	(2,233,321,242.63)	9,851,785,025.90
19	Тайлант үеийн үр дүн	-	-	994,704,868.00	994,704,868.00
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,010,432,655.62	4,074,673,612.91	(1,238,616,374.63)	10,846,489,893.90

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,465,331,200.00	9,412,518,131.93	(52,813,068.07)	99.4
12	Татварын бус орлого	9,465,331,200.00	9,412,518,131.93	(52,813,068.07)	99.4
120	Нийтлэг татварын бус орлого	630,600,000.00	1,236,335,366.58	(605,735,366.58)	196.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	608,100,000.00	1,177,852,316.58	(569,752,316.58)	193.7
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	22,500,000.00	58,483,050.00	(35,983,050.00)	259.9
122	Тусламжийн орлого	8,834,731,200.00	8,176,182,765.35	658,548,434.6	99.7
122005	Төсвөөс санхүүжих	8,834,731,200.00	8,176,182,765.35	658,548,434.6	99.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,465,331,200.00	9,412,518,131.93	52,813,068.07	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,465,331,200.00	9,412,518,131.93	52,813,068.07	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,111,056,000.00	9,065,336,846.47	45,719,153.53	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,447,036,200.00	7,443,044,676.95	3,991,523.05	99.9
210101	Үндсэн цалин	4,260,969,100.00	5,162,774,742.02	(901,805,642.02)	121.2
210102	Нэмэгдэл	1,968,692,900.00	1,743,334,245.82	225,358,654.18	88.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	460,165,900.00	389,270,505.11	70,895,394.89	84.6
210104	Урамшуулал	127,568,000.00	147,059,800.00	(19,491,800.00)	115.3
210105	Гэрээт ажлын хөлс	629,640,300.00	605,384.00	629,034,916.00	0.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	950,311,900.00	950,311,900.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	664,237,800.00	684,720,644.45	(20,482,844.45)	103.1
210202	Тэтгэмжийн даатгал	71,518,500.00	71,974,378.90	(455,878.90)	100.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,759,300.00	38,989,663.40	(3,230,363.40)	109.0
210204	Ажилгүйдлийн даатгал	35,759,300.00	30,402,714.00	5,356,586.00	85.0
210205	Эрүүл мэндийн даатгал	143,037,000.00	124,224,499.25	18,812,500.75	86.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,891,900.00	438,891,900.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	129,447,800.00	102,799,311.94	26,648,488.06	79.4
210302	Түлш, халаалт	84,220,400.00	107,906,248.11	(23,685,848.11)	128.1
210303	Цэвэр, бохир ус	45,212,700.00	43,186,339.95	2,026,360.05	95.5
210304	Байрны түрээс	180,011,000.00	185,000,000.00	(4,989,000.00)	102.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,551,000.00	23,261,400.00	3,289,600.00	87.6
210401	Бичиг хэрэг	3,992,900.00	4,438,230.74	(445,330.74)	111.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,858,400.00	9,737,400.26	2,120,999.74	82.1
210404	Ном, хэвлэл	150,000.00	150,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,566,000.00	300,000.00	1,266,000.00	19.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,983,700.00	8,635,769.00	347,931.00	96.1
2105	Нормативт зардал	113,177,600.00	113,177,425.00	175.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	883,200.00	883,125.00	75.00	100.0

**Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	112,294,400.00	112,294,300.00	100.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,192,500.00	10,168,400.00	24,100.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,192,500.00	1,192,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	9,000,000.00	8,975,900.00	24,100.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,137,000.00	80,890,644.52	32,246,355.48	71.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,946,200.00	74,945,244.52	30,000,955.48	71.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,245,300.00	3,245,300.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	319,300.00	-	319,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	134,400.00	-	134,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,491,800.00	2,700,100.00	1,791,700.00	60.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,757,900.00	5,590,500.00	6,167,400.00	47.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,494,900.00	1,494,900.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,263,000.00	4,095,600.00	6,167,400.00	39.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	354,275,200.00	347,181,285.46	7,093,914.54	98.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	354,275,200.00	347,181,285.46	7,093,914.54	98.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,815,100.00	66,815,100.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	287,460,100.00	280,366,185.46	7,093,914.54	97.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,657,995.00	(6,657,995.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,657,995.50	(6,657,995.50)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	453.00	453.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	223.00	223.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	195.00	195.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	219.00	219.00	-	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	39.00	39.00	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	6.00	6.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	148.00	148.00	-	100.0
650013	УТҮГ	25.00	25.00	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	10.00	10.00	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	10.00	10.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	337,343,261.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	337,343,261.00
122	Тусламжийн орлого	-	337,343,261.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	337,343,261.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	337,343,261.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	337,343,261.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	174,363,565.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	174,363,565.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	148,791,565.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	17,190,960.00
210101	Үндсэн цалин	-	5,204,660.00
210102	Нэмэгдэл	-	11,986,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	993,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	993,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	23,699,840.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,031,840.00
210602	Тавилга	-	1,188,000.00
210604	Урсгал засвар	-	12,480,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	106,514,465.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	106,514,465.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	393,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	393,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	25,572,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	25,572,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	25,572,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	162,979,695.24
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(162,979,695.24)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(162,979,695.24)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Консерватори нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Үндэсний их урлаг, дэлхийн сонгодог урлагийн бүтээлч хослол бүхий олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаталсан сургалт, судалгааны консерватори болох”-д оршино гэж тодорхойлсон байна.

Тус сургууль нь хөгжмийн дээд боловсролын байгууллага бөгөөд бүрэн дунд мэргэжлийн бакалавр, магистр, докторын боловсролтой чадварлаг мэргэжилтэн бэлтгэх, Монгол Улсын урлагийн салбарын хөгжил дэвшилд чиглэсэн эрдэм мэдлэг, соёлыг түгээх, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, шинжлэх ухааны судалгаа хийх, шинэ уран бүтээл, шинэ мэдлэг бүтээмж, сургалт, судалгаанд нэвтрүүлэх, инновацийн бодлого хэрэгжүүлэх, урлагийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтыг чанартай гүйцэтгэж, хүний нөөцийн бодлого боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Консерваторийн багш сурагчид 2025 онд эцэг эхчүүд асран хамгаалагчдын санхүүгийн дэмжлэгтэйгээр ОХУ, Солонгос, АНУ, Чех, Итали, БНХАУ зэрэг орнуудын олон улсын уралдаан, их наадмуудаас давхардсан тоогоор 300 гаруй сурагчид, оюутнууд Гран-При, тэргүүн болон дэд байруудыг эзэлсэн.
- Ж.Чулууны хөгжим “Уран Хас” бүжгэн жүжгийг Консерваторийн сонгодог бүжгийн тэнхим шинээр найруулан тавьж, Улаанбаатар Театрын тайзнаа тоглуулсан нь оюутан сурагчдын суралцаж байх хугацаандаа уран бүтээл туурвих мэргэжлийн үйл ажиллагаа болсон онцгой үйл явдал болсон байна.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд Консерваторийн захирал Ц.Шаравцэрэн Чех улсын Карлын Их Сургууль, Польш улсын Шопены хөгжмийн академ, Австри улсын Венагийн Хөгжмийн Их Сургуультай тус тус албан ёсны гэрээ байгуулан ажиллаж байгаагийн үр дүнд 1 оюутан Венад Ерасмус хөтөлбөрөөр суралцаж, 3 багш Варшавын олон улсын төгөлдөр хуурчдын уралдаанд олон улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр сонсогчоор оролцсон байна.
- Консерваторийн бакалаврын болон магистрын түвшний сургалтад Германы эрдэмтэн солилцооны байгууллага DAAD-ын санхүүжилтээр багш Ш.Гульфайруз, Д.Дармаа нар 3 долоо хоногийн хугацаанд зочин багшаар, жааз болон сонгодог хөгжмийн хөтөлбөрийн 3 оюутан нэг жилийн турш суралцаж байгаа нь Консерваторийн гадаад харилцаа болон Монгол Улсын их дээд сургуулийн түвшинд хэрэгжиж байгаа онцгой төсөл болж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Консерватори нь Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн САГ-2026/143/НА-СТА-ТШЗ

хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Сангийн сайдын А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Сангийн сайдын 240 тоот тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журам”;

Монгол Улсын Консерваторийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллага нь дотоод хяналтын ажилтан байхгүй, тайлант хугацаанд дээд шатны байгууллагаас дотоод аудитын шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллагын захирлын 2020 оны 125 дугаар тушаалаар батлан мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч шинээр гарсан нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар, журмын өөрчлөлтийг тусгаж шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 969,305.6 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,657.9	6,657.9	00
Авлага	92,989.8	1,079,793.9	986,804.1
Бараа материал	141,115.8	151,510.6	10,394.8
Үндсэн хөрөнгө	9,933,330.8	9,905,437.6	27,893.2
Нийт хөрөнгө	10,174,094.5	11,143,400.1	969,305.6
Өр төлбөр	322,309.5	296,910.2	(25,399.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,851,785.0	10,846,489.9	994,704.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,174,094.5	11,143,400.1	969,305.6

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Тайлант онд дансны авлагын үлдэгдэл 1,079,793.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 986,804.1 мянган төгрөгөөр өссөн нь аудитаар 374,071.9 мянган төгрөгийн төлөгдөөгүй сургалтын төлбөрийг авлагаар залруулж бүртгэсэн, төрийн сангаас гүйлгээ гаргаагүй, төвлөрүүлэн шилжүүлэгтэй холбоотой 705,092.1 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага бүртгэсэн нь нөлөөлсөн байна. Татаас санхүүжилтийн авлага нь төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого 605,735.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд байсан төрийн сангийн гүйлгээ хийгдээгүйгээс улсын төсөвт төвлөрүүлсэн 99,356.7 мянган төгрөгөөс бүрдэж байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 9,905,437.6 мянган төгрөг болж, 27,893.2 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 613 дугаар тогтоолын дагуу 26 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж 91,757.4 мянган төгрөгөөр өртгийг нэмэгдүүлсэн, 10,978.5 мянган төгрөгийн компьютер принтер худалдан авч, 132,725.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар хүлээн авсан. Тайлант онд 263,336.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.
- Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 25,399.3 мянган төгрөгөөр буурсан нь оны эхнээс татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр 270,176.6 мянган төгрөгөөр буурч төрийн сангийн гүйлгээ хийгдээгүйгээс 103,113.8 мянган төгрөгийн өр үүсч, аудитаар 141,663.5 мянган төгрөгийн урьдчилж орсон сургалтын орлогыг залруулж өглөгөөр бүртгэсэн зэрэг нь нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 994,704.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Судалгааны үр дүн: Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахад зориулагдсан Ординат ХХК-ийн 10,630.0 мянган төгрөгийн өртөгтэй Unicus санхүүгийн программ, сургалтын албаны үйл ажиллагаанд зориулагдсан 2,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Үүлэн их дээд сургуулиудын консорциум ГҮТББ-ын X Cloud программыг ашиглаж байна. Эдгээр программууд нь хэвийн ажиллаж байгаа бөгөөд программын хөгжүүлэлт буюу лицензийн төлбөрт жил бүр Ординат ХХК 1,460.0 мянган төгрөг, Үүлэн их дээд сургуулиудын консорциум ГҮТББ-д 6,720.0 мянган төгрөгийг төлдөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,180,045.4 мянган төгрөгөөр тооцож улсын төсвөөс 10,549,445.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 630,600.0 мянган төгрөг, нийт зарлагыг 11,180,045.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 2,117,745.6 мянган төгрөгөөр бууруулж, 9,062,299.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг өмнөх жилүүдийн түвшинд баталснаас шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг уур, ус дулааны үнийн өсөлттэй холбоотойгоор 405,357.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,834,731.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 630,600.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,804,510.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 1,236,335.3 мянган төгрөг бүрдүүлж, 9,412,518.1 мянган төгрөгийг зарцуулж 628,328.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнөөс 605,735.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.4 хувьтай байгаа нь төрийн сангаас гүйлгээ хийх эрх олгоогүйтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,896,141.4	8,878,097.3	18,044.1	99.8
2	80219 Харуул, хамгаалалтын зардал	73,222.3	73,222.3	-	100
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	287,460.1	280,366.2	7,093.9	97.5
4	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,723.9	1,722.9	1.0	99.9

**Монгол Улсын Консерваторийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5	81801 үдийн цай хөтөлбөр	66,815.1	66,815.1	-	100
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	112,294.4	112,294.3	0.1	99.9
7	82102 Олон улсын тэмцээн, уралдаанд	30,000.0	-	30,000.0	0
ДҮН		9,467,657.1	9,412,518.1	55,139.0	99.4

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

Монгол Улсын Консерватори нь бүтэц орон тооны тухайд батлагдсан орон тоо нь үндсэн үйл ажиллагааг явуулахад хүрэлцдэггүй, хөлсөөр ажиллах гэрээний дагуу 112 багш, ажилтныг ажиллуулж байгаа тул орон тооны цомхотгол хийх боломжгүй байна. Ажилчдад олгож байгаа хоолны хөнгөлөлт өдрийн 8.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 0.5 мянган төгрөг байсныг 2025 оны 9 сараас 2.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн. Тайлант хугацаанд гадаад томилолт, сургалтын зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, хэлэлцээр байхгүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 337,343.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 11,986.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлд 5,204.6 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 993.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 23,699.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 106,514.5 мянган төгрөг, тэтгэмж урамшуулалд 25,572.0 мянган төгрөг бусад зардалд 393.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж, улсын төсөвт 162,979.7 мянган төгрөгийг төвлөрүүлснээс 99,356.7 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаанд 231,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөнд тодотгол хийгдээгүй байна. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохион байгуулсан бөгөөд дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Хичээлийн 3-р байранд “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дотуур байрны хүүхдийн хоол хийх үйлчилгээ үзүүлэх, хичээлийн байранд харуул хамгаалалтын үйлчилгээ эрхлэх гэсэн 2 тендер зарлаж харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийсэн байна.

Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх тендерт Бүрэн дуулга ХХК шалгарч 118,800.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж сар бүр гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж санхүүжилтийг нь олгож байна.

“Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээний дүн 66,815.1 мянган төгрөг, дотуур байрны сурагчдын хоол хийх үйлчилгээ үзүүлэх гэрээний дүн 112,294.3 мянган төгрөгийн тендерт Найст-Арч ХХК шалгарч гэрээний үүргийг ханган ажиллаж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Улсын Консерватори , түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хөрөнгийн тооллогыг чанартай хийх, үр дүнг санхүүгийн тайланд тусгахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, туслах аудитор Ж.Золжаргал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Насанбуян нар аудитын үе шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Консерватори ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,488,301.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 94,883.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд арга хэмжээ авч ажилласнаар тайлант жилд байгууллагын эдийн засгийн үзүүлэлт сайжирсан байна. Аудиторын хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн САГ-2026/143/НА-СТА-ТШЗ

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 6,957,235.0 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих нийт 169 мэдээллээс 13 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацааг хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 28 гүйлгээ, зарлагын 7 гүйлгээг тус тус байршуулаагүй, мөн орлогын 12 гүйлгээ, зарлагын 67 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд ауди таар өгсөн зөрчил дутагдлыг арилгах..", 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу харуул хамгаалалтын үйлчилгээ, хичээлийн 3-р байранд “үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх дотуур байрны хүүхдийн хоол хийх үйлчилгээ эрхлэх түрээслэгчийг сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулан гэрээ байгуулан ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2-р улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 3,677,902.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 16,269.3 мянган төгрөгийн 1 алдааг арилгасан, 3,661,632.9 мянган төгрөгийн 3 алдаа зөрчлийг аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 496,759.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 412,952.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн биелэлт 100%, албан шаардлагын биелэлт 80.6 хувьтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	496,759.1	1	400,000.0	80.6
Зөвлөмж	2	412,952.5	2	412,952.5	100
Нийт дүн	3	909,711.6	3	812,952.5	89.3

Өмнөх онд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд зөрчлийг давтан гаргасан буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025.01.03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт сайжруулалт хийсэн эсэхийг анхаарах;
2. Улсын төсөв, Боловсролын яамны санхүүжилтээр 300 оюутны дотуур байр баригдаж барилгын ажил дуусч байгаатай холбоотойгоор хөрөнгийн бүртгэл, гүйцэтгэл дээр анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 626,970.4 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Тус сургууль нь дээд сургуулийн сургалтын төлбөрийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс тайлант онд 374,071.9 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлж, авлагын дүнг буруу тайлагнасан;
- Суралцагсдын төлсөн дараагийн семестрийн сургалтын төлбөрийн орлогыг тухайн тайлант үед ногдох хэмжээгээр нь хуваарилахгүйгээр төлсөн нийт дүнгээр нь тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрч, санхүүгийн үр дүнг 141,663.5 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн;
- Тус байгууллага нь 2025 онд 52,132.8 мянган төгрөгийн ХАОАТ-ын өглөгийн үлдэгдэлтэй байхад татварын цахим системд 59,102.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэсэн зөрүүтэй бүртгэл үүссэн байсныг тайлант хугацаанд 111,234.9 мянган төгрөгөөр өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн данс руу бичилт хийж, 59,102.1 мянган төгрөгийн татварын авлага бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27, 29 дүгээр параграфт заасныг хангахгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 322.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 322.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, хөрөнгийн тооллоготой холбоотой асуудалд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 322.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 85,536.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын захирлын 2025 оны Б/180 дугаар тушаалаар ажлын 5 хоногийн цалингүй чөлөө олгосон ажилтанд тухайн хугацааны цалин 322.6 мянган төгрөгийг бүрэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Ажилтанд илүү олгосон цалинг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.3 Зөвлөмж

1. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх тухай захирлын тушаал гарч, тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож, тооцоо бодсон акт үйлдээгүй, илгэх хуудас бичээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай хийж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж байх, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тус сургууль нь дээд сургуулийн сургалтын төлбөрийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс тайлант онд 374,071.9 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлж, авлагын дүнг буруу тайлагнасан байна.	1	374,071.9	1	374,071.9			1	374,071.9				
2	Суралцагсдын төлсөн дараагийн семестрийн сургалтын төлбөрийн орлогыг тухайн тайлант үед ногдох хэмжээгээр нь хуваарилахгүйгээр төлсөн нийт дүнгээр нь тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрч, санхүүгийн үр дүнг буруу илэрхийлсэн байна.	1	141,663.5			1	141,663.5		141,663.5				
3	Тус байгууллага нь 2025 онд 52,132.8 мянган төгрөгийн ХАОАТ-ын өглөгийн үлдэгдэлтэй байхад татварын цахим системд 59,102.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэсэн зөрүүтэй бүртгэл үүссэн байсныг тайлант хугацаанд 111,234.9 мянган төгрөгөөр өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн данс руу бичилт хийж, 59,102.1 мянган төгрөгийн татварын авлага бүртгэж тайлагнасан байна	1	111,234.9			1	111,234.9		111,234.9				
	Дүн	3	626,970.4	1	374,071.9	2	252,898.4		626,970.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Байгууллагын захирлын Б/180 тоот тушаалаар ажлын 5 хоногийн цалингүй чөлөө олгосон ажилтанд тухайн хугацааны цалинг бүрэн олгосон байна.	1	322.6	1	322.6								
2	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх тухай захирлын тушаал гарч, тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож, тооцоо бодсон акт үйлдээгүй, илтгэх хуудас бичээгүй байна.	1	-					1					
	Дүн	2	322.6	1	322.6			1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих нийт 169 мэдээллээс 13 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацааг хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 28 гүйлгээ, зарлагын 7 гүйлгээг тус тус байршуулаагүй, мөн орлогын 12 гүйлгээ, зарлагын 67 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1	-	1	-		
	Дүн	1	-	1	-		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 58/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/143/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Консерваторын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын захирлын 2025 оны Б/180 дугаар тушаалаар ажлын 5 хоногийн цалингүй чөлөө олгосон ажилтанд тухайн хугацааны цалин 322,608.00 /гурван зуун хорин хоёр мянга зургаан зуун найман/ төгрөгийг бүрэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтанд илүү олгосон 322,608.00 /Гурван зуун хорин хоёр мянга зургаан зуун найман/ төгрөгийг нягтлан бодогч /Б.Амарзаяа/-р нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Консерваторын захирал /Ц.Шаравцэрэн/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 283/A0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/143/МА - СТА - ТШЗ

Сахилгын хариуцлага тооцох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Консерваторын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих нийт 169 мэдээллээс 13 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацааг хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 28 гүйлгээ, зарлагын 7 гүйлгээг тус тус байршуулаагүй, мөн орлогын 12 гүйлгээ, зарлагын 67 гүйлгээг тус тус хугацаа хоцроож, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулаагүй, төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч /Б.Амарзаяа/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Консерваторын захирал /Ц.Шаравцэрэн/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Я.НАСАНБУЯН